

МЕНГ НЬЮ АЖ АХУЙН /КОРПОРАЦИ/-ИЙН СОЁЛЫН ТУХАЙ

*Хөгжилт**
*Баатар***

Хүн болоход хүний ёсыг дагаж, аж ахуй эрхлэхэд менежментийн ухааныг мөрдөх хэрэгтэй. Аж ахуйн соёл нь яг л хүний гентэй адил, цаг бус үгүй, хааяа үгүй оршдог. Суурь машин, хөрөнгө мөнгө, түүхий эд материал, үйлдвэрийн газар ашиглалтад орсон цагаасаа өнөөх аж ахуйн гентэй болж, ямар логицоор, яаж эргэлдэх нь аж ахуйн соёлоос шалтгаална.

1. Аж ахуйн соёлыг эрхэмлэгсэд эрхэмсэг үйлст ханддаг.

Хүний ажлын байдлыг 3 зүйлд хувааж болно. Амаар ажиллах, биеийн хүчээр ажиллах, амь хайргүй ажиллах, нэг хүн энэ 3 зүйлийн алинаар нь ажиллах, тэр хүний хэв чанартай хамаатайгаас гадна аж ахуйн соёл, гүн ухаанаас их нөлөөлнө.

Мэнг нью аж ахуйн соёлын мөн чанар бол “өөрсөдтэйгээ мөрийцэх”-д бий. “Өөрсөдтэйгээ мөрийцөх” хийгээд “бусадтай мөрийцөх” бол хоёр зүйлийн соёлын үзэл байж, өмнөх нь өөрийгөө дээшлүүлэх харалттай. Хоёр дахь нь өрсөлдөгчөөн дарах харалттай. Нэг сайн шошгийг буй болгох нь өрсөлдөгчөөн үгүйсгэснээс болж буй биш харин хэрэглэгчийн сонголтын үр дүнгээс болно. Хэрэв хэрэглэгчдэд нэн их хэрэгтэй бүтээгдэхүүн буй болгосон байвал хэрэглэгч түүнийг сонгоно. Иймээс ямар ч байдалд бусадтай атаархсанаас аливаа шалтгааныг өөрөөсөө эрж хайвал зохистой.

Мэнг нью буй болсон цагаасаа “100 жилийн Мэнг нью” гэсэн байр суурь баримталж “урт наслах ген”-ийг эрэлхийлсний үр дүнд тэдгээр нь бүр хамтын нэг онцлогтой байхыг ухааран мэджээ. Энэ бол даруй аж ахуй эрхлэх нь зөвхөн аж ахуй эрхлэх төдий биш тэрчлэн ажил үйлсээ сайн хийж, нийгмээ бүтээн байгуулах хэрэг болой. Иймээс тэд нэртэй шошго буй болгох, сайн зан суртахуунтай байх, их ашиг олох 3 зорилтыг дэвшүүлжээ.

Нэртэй шошго буй болгох гэдэг нь Өвөр Монгол хэмээх нэртэй шошгыг буй болгох явдал болой. “Бүх орныг хараагүй хүн өнцөг буланых ч эзэмдэж дийлэхгүй. Буман цагийг бодол хэлсэнгүй хүн нэгэн цагийг ч эзэмдэхүйеэ хүчир” гэсэн үг байдаг. Мэнг нью нь Хөх хотын нэг хүнд ногдох сүүний хэмжээгээр, сүүний үйлдвэрлэлийн өсөлтийн хурдацаар

* Хөгжилт - БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн Хөрш орон судлалын хүрээлэнгийн судлаач

** Баатар - Өвөр Монголын Зүүн хойт Ази судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

бүх улсад тэргүүлдэг бодит байдалд тулгуурлан Хөх хотыг “Хятадын сүү цагаан идээний төв” болгох үзэл баримтлалыг дурдсан байна.

Сайн зан суртахуунтай байх гэсэн нь ажилдаа шударга байж, эрхэм дээд зан суртахуунтай хамт олныг буй болгох явдал юм. Мэнг нь нь “хүний сэтгэлийг эзэмдэх” гэж ярьдаг. Жишээлбэл цагаан сарын золголтод дээд шатных нь доод шатны хүндээ золголт хийж, доод шатных нь дээд шатны хүндээ золгож болохгүй. Үүний хамт ямар ч хэлбэрийн “мөнгөн хөрөнгийн эргэлт”-ийг эсэргүүцэж хурим найр, төрсөн өдрийн баяр, шинэ байранд ороход ширээ будаа засаж болдог боловч бэлгийн мөнгө, бэлгийн зүйлс авахыг эрс зөвшөөрөхгүй. Мэнг нь-гийн хүн бүр ажлын уриа үгтэй байхыг шаарддаг хийгээд гэдний захирлын зөвлөмж үг бол “бага ялалтад оюуныг түшиж их ялалтад ёсныг түшмөй”.

Их ашиг олох гэдэг нь стратеги тогтоох явцад хувьцаа эзэмшигчид, банк, ажилтан, түнш болон нийгэм энэ бүгдээр сэтгэл хангалуун байхыг аж ахуйн үндэс болгож, түүнийгээ 5 үгээр багцалсан байдаг. Энэ нь “хувьцаа оруулсан бол ашиг хуримтлалын төлөө, банк зээллэг өгсөн бол хүү мөнгөний төлөө, ажилтнууд ажилласан бол орлогын төлөө, түнш хамтарсан бол хамтын ашгийн төлөө, орон нутгийн дэмжлэг татварын төлөө”.

Ашгийн тогтомжид хэрэглэгчийн ашиг гол байрт орж тэр нь бусад ашгийг биелүүлэхийн эх үүсвэр болдог. Иймээс Мэнг нь нь хэрэглэгчдэд үнэн итгэлцэл буй болгохыг их анхаарч тал нутгийн үнээний сүүний ууган үнэр амтыг батлахын тулд 1999 онд үйлдвэр анх байгуулах бэл мөнгө хүрэлцэхгүй байдалд улсын дотоодын анхны сүүний тоног төхөөрөмжийн ариутгах цехийг байгуулж, үүний төлөө хэдийгээр жил бүр хэдэн сая юаний зарлага гаргасан ч нэн их хэмжээний хэрэглэгчийн хүрээг олсон байна.

2. Суралцах хэлбэрийн аж ахуйн соёл нь аж ахуйг дээд шатанд гаргана.

Хүн болон амьтны нэг ялгаа нь хүн бичиг үсэгтэй, харин амьтанд байхгүй. Иймээс амьтны үе бүр нь анхны байртаа буцаж тэгээс эхэлж хүн харин эрт эдүгээгийн тэмдэглэл бичгийг уншиж чармайлттай хүн өмнөх хүний бүтээлийг гүйцэд ашигладаг.

Мэнг нь үйлдвэрийн газарт 100-гаад санамж бичиг байдаг. Жишээлбэл “хэрэв чи ухаантай бол ухаанаа гаргаад ажилла, хэрэв ухаан дутуу бол хөлсөө гаргаж ажилла, хэрэв чи ухаан дутуу мөртлөө хөлсөө гаргахыг хүсэхгүй бол манай үйлдвэрээс явж болно”, “бүтээгдэхүүний чанарын сайн муу байх нь чиний ажлын сайн муугаас болно”, “өөрийн гэрэл гялбаагаа цацруулахдаа бусдын дэнг бүү үлээ”. Эдгээр санамж бичиг нь санаатай санаагүйн хооронд ажилтан бүрийн үзэл санаа үйл ажиллагаанд нөлөөлж байдаг юм.

Эрт эдүгээ Хятад гадаадаас сурч залгамжлахад түүний хэлбэрийг дууриах нь амар боловч үнэн санааг нь олох нь хүчир юм. Шинжлэх ухааны залгамжлал бол шалган тогтоох явдал болой. Иймээс хамаг чухал нь мэдлэг олоход байх биш харин үзэл санааны арга хэлбэрийг олоход бий.

Биологийн ухаанд “эрлийзжүүлэлтийн давуу тал” гэж байдаг. Биологийн эрлийзжүүлэлтээс шилдэг үүлдэр үүсдэг бол үзэл суртлын эрлийзжилтээс үзэл санааны аварга хүн буй болдог. Бидний үзэл санааг нэг ширхэг өндгөөр жишвэл суралцлага нь өнөөх өндөгт тахианы ангаахай төрүүлэх орчинг үүдэн бүтээдэг. Хятад, Европ соёлын хэлхээ холбоонд өөрийн ойлголт болон бусдын ойлголтын мөргөлдөөнд Мэнг нь юу нь үзэл санаа хийгээд үзэл санааны үржвэрийн үр дагаврыг буй болгосон байна.

3. Шинийг бүтээх хэлбэрийн аж ахуйн соёл нь лидер маягийн аж ахуйг буй болгодог.

Мэнг нь юу нь гадаадын туршлагаас суралцахын хамт шинээр бүтээн бий болгоход анхаарсан байна. Жишээлбэл бодлого тогтоох явцад хүн бүр сохор гэдэг “бүгд сохрын хууль”-ийг дурдан гаргажээ. Эд баялаг ашиглалтын талаар оюуны хүч, биеийн хүч, санхүүгийн хүч хоорондын диалектик холбоог уялдуулсан “3 хүчний журмыг” дурджээ. Аж ахуй эрхлэлтэд зорилт явцыг тогтоох “зорилтын тонгоруу арга”-ыг дурджээ. Хүн сонгож хэрэглэхэд дутагдал байхгүй бол давуу тал байхгүй гэсэн “хувирмал хорхойн онол”-ыг дурджээ.

Нэгэн суутан хэлэхдээ “нэг лан ген нь нэг тонн боловсролыг төрүүлдэг” гэжээ. Гений инженерчлэл бол дэлхий дээрх хамаг будлиантай хамаг агуу инженерчлэлийн нэг байж, гуа тарьвал гуа болж, борцог тарьвал борцог хураадаг. Соёлын зураг төлөвлөгөө дэх нэг алхам давшилт нь аж ахуйн өөрчлөлтөд их дэвшлийг авчирч өгч мэднэ. Бүтээгдэхүүнд соёлын генийг тарьж оруулсан цагт муухай дэгдээхэй цагаан хун болж болох юм.

Эдийн засгийн даяаршлын орчинд бүх бөмбөрцгийн аж ахуй бүр нэгдэлтэй том зах зээлтэй золгож, бараа бүтээгдэхүүнд улсын хил байхгүй, чадвартанд улсын хил байхгүй, бэл мөнгөнд улсын хил байхгүй болж бүх бөмбөрцгийн өрсөлдөөнд соёлын өрсөлдөх хүчийг олъё гэвэл заавал соёлын бүх бөмбөрцгийн хараатай байж, гурван инженерчлэлийг сайтар хийх хэрэгтэй. Энэ гурван инженерчлэл бол суурь тавих, залгалт, ген шилжүүлэх инженерчлэл болой.